



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГАЗРЫН ДАРГА
Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.23 № 01/33 ЧАГ/САГ/2014/24 /-СЛ/А-П/ШЗ

Зөрчлийг арилгуулах тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн газрын 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Нормын хувцас, зөвлөн эдлэл худалдан авах зардлаас дүрэмт хувцасны загвар, лого зохион бүтээлгэх болон албаны дүрэмт хувцас худалдан авахаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 209.9 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилан шилжүүлэн, авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдөр “Хос аз”, “Амно фэйшн”, “MB summit” ХХК-иуд, ШУТИС-ийн “Хувцас судлалын төв”, иргэн О.Одонболдтой байгуулсан 02, 04, 05, 06, 07 тоот гэрээний 3 дугаар зүйлийн 3.2 дахь “Гүйцэтгэгч нь бүтээгдэхүүнийг захиалагчид бүрэн гүйцэд хүлээлгэж өгснөөр захиалагч төлбөрийг 100 хувь төлнө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, МУ-ын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-д заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

Санхүүжилтийг урьдчилан авсан иргэн, аж ахуй нэгжүүдтэй холбогдох тооцоог бүрэн хийж, авлагыг барагдуулан биелэлтийг 2014 оны 7 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус газрын дарга Б.Пүрэвдорж, Ерөнхий нягтлан бодогч Д.Мөнгөнцэцэг нарт хариуулав.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТОР

С.БАТ-ЭРДЭНЭ

УХА0122